



САНГИЙН САЙД Ч.УЛААН
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013. 06. 05 № 128 ҮНДСАГТ ГАЗРЫН ТАЙЛАНД АУДИТ

Зөрчил арилгах тухай

Засгийн газрын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сангийн яам 2007 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр Анод банкинд хугацаагүй хадгаламжийн данс нээж Япон Улсын тусlamжийн 1,582.0 сая төгрөгийг байршуулж, 2007-2009 онд нийт 9 удаагийн гүйлгээгээр 8,302,160,244.17 төгрөгийн орлогыг төвлөрүүлж, зарлага гараагүй бөгөөд 2012 оны эцэст нийт 9,884,187,077.17 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Япон Улсын тусlamжийн харилцах дансны 9,884.2 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 1,419.3 сая төгрөгөөр дутуу тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-д “санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх”, 7 дугаар зүйлийн 7.7-д “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно”, 19 дүгээр зүйлийн 19.1.4-д “... худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд “Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 1-ийн 12 дугаар заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1 дүгээр заалтыг үндэслэн төрийн сангийн тайлангийн мөнгөн хөрөнгийн 9,884,187,077.17 үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулахыг Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын дарга Т.Доржханд, Төрийн сангийн газрын дарга Ч.Тавинжил нарт үүрэг болгож, албан шаардлага хүргүүлж байна.

Албан шаардлагын биелэлтийг 2013 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг мэдэгдье.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
АХЛАХ АУДИТОР



Ч.БОЛД

УХА0122